



## “ЦЭСБ-АУДИТ” ХХК

УБ дахь оффис: ЧД 03-р хороо, Төмөрчний гудамж;  
 “Эрдэнийн тойрог” ХХК-ийн байрны 01-р давхар, 108 тоот;  
 Утас: 99099605; 99019203, Ш/хаяг-erkaa0315@yahoo.com

2019 / 02 / 23 № 192 / 122

## “ ДОРНОД ХУДАЛДАА ХК-ИЙН УДИРДЛАГАД ”

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

#### Дүгнэлт

Бид “ Дорнод худалдаа ” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болгосон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд, нэмэлт тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь материаллаг асуудлаар Монгол Улсын холбогдох хууль, дүрэм, журмын дагуу үнэн зөв толилуулагдсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа “Аудиторын үүрэг хариуцлага” гэсэн хэсэгт харуулсан. Бид энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ажиллаж, бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж бид үзэж байна.

#### Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээлэлд хамааралгүй болно.

#### Санхүүгийн тайлантай холбоотойгоор компанийн удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн

... дүрэм, журмуудыг буруу илэрхийлэлгүй Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтын талаарх хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайлан гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан боддох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### **Аудиторын үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан ба алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүнгүүд болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэдэг. Сонгосон горимууд нь аудиторын үнэлэмж, түүний дотор залилан эсвэл алдаанаас шалтгаалсан санхүүгийн тайлан дахь материаллаг алдаатай тайлагналын эрсдэлийн үнэлгээнээс хамаардаг. Эдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор нь тухайн байгууллагын дотоод хяналтын үр өгөөжийн талаар дүгнэлт гаргах зорилго тавилгүйгээр, тухайн нөхцөл байдалд тохиромжтой аудитын горимуудыг тодорхойлохын тулд, санхүүгийн тайлангуудыг байгууллага бэлтгэж үнэн зөв толилуулахтай хамаатай дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн аудитаар тухайн хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн зохистой байдал болон тооцооллын ул үндэслэлийг үнэлж, мөн санхүүгийн тайлангуудын нийт толилуулгыг үнэлдэг.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ч.ЦЭРЭННАДМИД